



## ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг: [enkzayas@audit.gov.mn](mailto:enkzayas@audit.gov.mn)

Аудитын менежер: Л.Одгэрэл

Утас: 260512

Цахим хаяг: [odgerell@audit.gov.mn](mailto:odgerell@audit.gov.mn)

Ж.Батсайхан

Утас: 261628

Цахим хаяг:  
[batsaikhanj@audit.gov.mn](mailto:batsaikhanj@audit.gov.mn)

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр  
Бага тойруу 6  
Улаанбаатар-46  
Монгол улс

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2014 оны 4 дүгээр сар

### АУДИТЫГ ДУУСВАР БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН

Агуулга

Оршил  
Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ  
Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс,  
гаргасан шийдлүүд  
Залруулаагүй алдаа  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн  
тайлан

**Хавсралт 4:** Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

## **Оршил**

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг тус газрын удирдлагад танилцуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх хуулийн хугацаанд аудит хийгдээгүй төсвийн шууд захирагчийн санхүүгийн зарим үйл ажиллагаанд түүвэр сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлэв.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, объект дээрх үе шат, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### **Санхүүгийн дотоод хяналтын үнэлгээ**

Бид үйлчлүүлэгчийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс байгууллагын санхүүгийн дотоод хяналтыг аудитын горимын дагуу дахин хянасан.

Аудитын явцад Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд үйл ажиллагаандаа холбогдох стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсөвт байгууллагад мөрдөх УСНББОУС-ийн бодлого, заавар, журмыг баримталж ажилласан байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын ахлах рефферент Б.Цэрэнжигмэд хяналт – шинжилгээ, үнэлэгээ, дотоод аудитын асуудал хариуцдаг бөгөөд Засгийн газрын 2006 оны 160, 2009 оны 285 дугаар тогтоолоор батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тэрээр Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг, бусад эрх зүйн акт, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Харин тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудалд аудит хийгээгүй байна.

### **Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансны нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, түүвэр сорил хийхээр төлөвлөсөн байгууллагын

дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

### **Асуудал 1: Хөрөнгийн талаар**

Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн захирлын 2013 оны 88 дугаар тушаалаар байгуулсан хөрөнгийн тооллогын комисс тус хүрээлэнгийн 2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого явуулах явцад 6 нэрийн 0,255 сая төгрөгийн тавилга эд хогшил, 10 нэрийн 1,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 1,36 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл, тайланд тусгагдаагүй, ажиллагсад дээр ашиглагдаж байсныг илрүүлж, тооллогын комиссын дүгнэлт, тайланд тусгасан байна.

Гэтэл нягтлан бодогч эдгээр хөрөнгийг зохих журмын дагуу үнэлүүлж, нягтлан бодох, бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.3-т заасан “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалтыг биелүүлээгүйтэй холбоотой байна.

Эд хөрөнгийн тооллого хийх явцад илрүүлсэн байгууллагад ашиглаж байгаа хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөл болон тооллогын комисстой хамтран бүртгэл, тайланд тусгаагүй шалтгааныг тогтоож, зохих журмын дагуу үнэлж, бүртгэл, тайланд тусгахыг зөвлөв.

### **Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар**

Ерөнхийлөгчийн тамгын газар 2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т заасан хугацаанд хөрөнгийн төрөл тус бүрээр зохих журмын дагуу хийж, баталгаажуулаагүй байна.

Тухайлбал; 2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2013 оны 9 дүгээр сард Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд даргын 2013 оны 200 дугаар тушаалаар комисс томилж, эд хөрөнгийн тооллого явуулсан боловч тооллогын комиссын дүгнэлтийг үндэслэж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах тухай Ерөнхийлөгчийн тамгын газрын дэд даргын 2013 оны 221 дүгээр тушаалаар өгсөн үүргийн биелэлт хангалтгүй, жилийн эцсийн тооллогыг зохих шаардлагын дагуу хийж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь төрийн өмчийн эд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт, хангалтгүй байгааг харуулж байна.

### **Асуудал 3: Өглөг, авлагын талаар**

Аудитын явцад МИАТ ХК-тай байгуулсан Онцгой үүргийн нислэг үйлдэх гэрээний дагуу үүссэн тооцооноос 29,8 сая төгрөгийн төлбөрийг Ерөнхийлөгчийн

тамгын газар хүлээн зөвшөөрөхгүй байна гэсэн асуудлыг холбогдох баримт материалд тулгуурлан шалгаж, шийдвэрлэв.

Тус газар дээрх төлбөрийг төлөхгүй гэх шалтгаан нь Ерөнхийлөгчийг дагалдан явсан бусад байгууллагын хүмүүсийн онгоцны тийзийн мөнгийг Ерөнхийлөгчийн тамгын газрын тооцоонд оруулж тооцсонтой холбоотой бөгөөд хоорондын тооцоог 2 талаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулав.

#### **Асуудал 4: Худалдан авах ажиллагааны талаар**

Төлөвлөсөн ёсоор Ерөнхийлөгчийн тамгын газрын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг Сангийн яаманд хүргүүлсэн тайлантай тулган баталгаажуулж, худалдан авах ажиллагааг иж бүрэн, бодитой төлөвлөж, тайлагнасан эсэхийг тулган баталгаажуулав.

Тус газар худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар багцын хэмжээний худалдан авах ажиллагааг нэгтгэж, удирдах боломж бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **Асуудал 5: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Ерөнхийлөгчийн тамгын газарт өмнөх аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т заасан *“Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь санхүү, бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөж ажиллана”* гэсэн заалтын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөсөн болно.

Гэвч тус газар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч, баталгаажуулах хэмжээнд шаардлага хангаагүй гэх шалтгаанаар албан ёсоор баталгаажуулаагүй байна.

Тухайлбал; дээрх баримт бичгийн төслийг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлага байгаа бөгөөд өөрийн байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалттай уялдуулах нь зүйтэй гэж үзлээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын онцлог, эрх зүйн орчинтой нийцүүлэн боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд стандартын дагуу үнэн зөв тусгах, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг батлагдсан хэмжээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу зөв ангилж бүртгэх, тайлагнах, төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг хангаж ажиллах зэрэг үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, стандартын хүрээнд явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Энэ асуудлыг холбогдох хүмүүстэй зөвшилцөж, зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

### **Асуудал 6: Нягтлан бодох бүртгэл, тайлагналын талаар**

Ерөнхийлөгчийн тамгын газар 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт ирүүлэхдээ санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны үлдэгдлийг тусгалгүй ирүүлснийг аудитын явцад засууллаа.

Эдгээр асуудал болон санхүүгийн дотоод хяналтын талаарх бидний үнэлэлт дүгнэлт, менежментийн захидалтай нийлээд аудитаар илрүүлсэн гол зүйлсийг бүрдүүлж өгнө.

### **Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 20.0 сая, нийт зарлага 11,139.9 сая төгрөгөөр батлагдсаны дотор 10,777.9 сая нь урсгал зардал, 362.0 сая нь хөрөнгийн зардал байна.

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд тайлант хугацаанд 7,4 тэрбум зарцуулж, батлагдсан төсвийг 33,5 хувь буюу 3,7 тэрбум төгрөгөөр хэмнэжээ. Харин урсгал төсвийн 67,3 хувь буюу 7,24 тэрбум төгрөгийг зарцуулж, 3.5 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна.

Урсгал зардлын дээрх хэмнэлт нь цалинтай холбоотой зардал 85,12 сая, бараа үйлчилгээний бусад зардал 3,421.5 сая зарцуулаагүйтэй холбоотой байна.

Төсвийн хэмнэлт нь төлөвлөсөн орон тооноос 3 хүн дутуу ажилласан, төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүй хийсэн, төлөвлөсөн ажлыг тайлант хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитын тайланд нэгтгэсэн бөгөөд төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу Ерөнхийлөгчийн тамгын газраас албан ёсоор гаргуулж, баталгаажуулан ажлын баримтад хавсаргав.

### **Залруулаагүй алдаа**

Аудитын олон улсын стандартын дагуу аудитын явцад илрүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй материаллаг биш аливаа алдаа, зөрчлийг тухайн байгууллагын удирдлагын анхааралд хандуулах шаардлагатай байдаг.

Дээрх шаардлагын дагуу энэ удаагийн аудитаар илэрсэн зарим алдаа зөрчлийг арилгах, цаашид дахин давтан гаргахгүй байхыг аудитын явцад үүрэг болгож, асуудлын бүртгэлд 6 асуудал тусгасанаас Ерөнхийлөгчийн тамгын газрын удирдлагад 4 асуудлын мөрөөр холбогдох арга хэмжээ авах зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийг тусгайлан Менежементийн захидалд тусгасан болно.

Аудитаар залруулаагүй нийт 1,4 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрч аудитын тайланд тэмдэглэв.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2012 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 5 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжид төсөвт зардлын гүйцэтгэл, автомашины ашиглалтад тавих хяналтыг сайжруулах, худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж баталгаажуулах, санхүүгийн програм хангамжийн алдааг засаж, залруулах асуудал багтсан байна.

Тус газар өмнөх аудитын зөвлөмжийн биелэлтийг гаргаж ирүүлэхдээ дээрх зөвлөмж, дундажаар 96 хувийн биелэлтэй гэж, тооцсон ч аудитын явцад зөвлөмжийн биелэлттэй холбоотой асуудалтай танилцахад зөвлөмжийн биелэлт 62 хувьтай гэж үзлээ.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор өмнөх шатанд хийсэн аудитын дүнг үнэлж, нэгтгэх, аудит хийгдээгүй зарим байгууллагын харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлтүүдтэй тулган шалгав.

Багцын хэмжээний 2013 оны төсвийн гүйцэтгэлийг материаллаг байдлын суурь үзүүлэлт болгож, аудитын явцад тооцсон эрсдэлийг харгалзаж материаллаг байдлын түвшинг суурь үзүүлэлтийн 1 хувиар тооцсон бөгөөд нийт зөрчил нь материаллаг байдлын түвшингээс доогуур байна.

Иймээс бидний дүгнэлтээр Ерөнхийлөгчийн тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь бүгд материаллаг зүйлсийн хувьд 2013 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Монгол улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.





**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чөөгэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 671

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Ерөнхийлөгчийн тамгын газрын удирдлага Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө / өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД



# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## Менежментийн захидал

Агуулга

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

### **Асуудал 1**

Үндсэн хөрөнгийн талаар

### **Асуудал 2**

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох талаар

### **Асуудал 3**

Худалдан авах ажиллагааны талаар



## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Энэ тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа бөгөөд Ерөнхийлөгчийн тамгын газрын удирдлагад хандсан болно.

Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Ерөнхийлөгчийн тамгын газрын санхүү, бүртгэлийн ажилтнууд болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.**

**Ажиглалт**

Ерөнхийлөгчийн тамгын газрын харьяа Үндэсний хөгжлийн хүрээлэн эд хөрөнгийн тооллого явуулах явцад 1,365.0 мянган төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл, тайланд тусгагдаагүй, ажиллагсад дээр ашиглагдаж байсныг илрүүлж, тооллогын комиссын дүгнэлт, тайланд тусгасан байна.

Гэтэл нягтлан бодогч эдгээр хөрөнгийг зохих журмын дагуу үнэлүүлж, нягтлан бодох, бүртгэл, тайланд тусгаагүй байна.

Ерөнхийлөгчийн тамгын газар 2013 оны жилийн эцсийн эд хөрөнгийн дотоодын тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т заасан хугацаанд хөрөнгийн төрөл тус бүрээр зохих журмын дагуу хийж, баталгаажуулаагүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай иж бүрэн байх, толилуулга ба илчлэлийн талаархи батламж мэдэгдэл зөрчигдөх эрсдэл байна.

**Зөвлөмж**

Эд хөрөнгийн тооллого хийх явцад илрүүлсэн байгууллагад ашиглаж байгаа хөрөнгийг өмч хамгаалах байнгын зөвлөл болон тооллогын комисстой хамтран бүртгэл, тайланд тусгаагүй шалтгааныг тогтоож, зохих журмын дагуу үнэлж, бүртгэл, тайланд тусгуулах;

Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т заасан хугацаанд хөрөнгийн төрөл тус бүрээр зохих журмын дагуу хийж, баталгаажуулах, тооллогын үр дүнг энэ хуулийн 73.2-т заасан нөхцөл шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаж байх;

Эдгээр зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

**Ажиглалт**

Үндэсний аудитын газар Ерөнхийлөгчийн тамгын газарт өмнөх аудитаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.2-т заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, баталгаажуулан санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөсөн болно.

Тус газар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч, баталгаажуулах хэмжээнд шаардлага хангаагүй гэх шалтгаанаар албан ёсоор баталгаажуулаагүй байна.

Тухайлбал дээрх баримт бичгийн төслийг санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгох шаардлага байгаа бөгөөд өөрийн байгууллагын санхүү, бүртгэлийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалттай уялдуулах нь зүйтэй гэж үзлээ.

**Эрсдэлүүд**

Нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого тодорхойгүй байснаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд буруу тусгах;

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого, зарлагыг буруу ангилж бүртгэх;

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг тухай бүр хангаж ажиллахгүй зөрчил дутагдал гаргах;

Эдгээрээс гадна санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй юм.

**Зөвлөмж**

Одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, шинээр батлагдсан Төсвийн тухай хууль, тогтоомж зэрэг стандарт, эрх зүйн орчны шинэчлэл, бодлогын өөрчлөлтэй уялдуулан боловсронгуй болгож, 2014 оны эхний хагас жилд багтаан баталгаажуулах;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

**Ажиглалт**

Ерөнхийлөгчийн тамгын газар худалдан авах төлөвлөгөө, тайланг зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний жагсаалтад үндэслэн гаргасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн төлөвлөж, тайлагнаагүйг харуулж байна.

Төсвийн багцын тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу төсвийн хөрөнгө оруулалт, урсгал төсөв, өөрийн хөрөнгө, зээл, тусламжийн хөрөнгө зэрэг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр, иж бүрэн төлөвлөж, тайлагнах ёстой.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн тайланг толилуулахдаа гаргадаг бодит байдлын тухай үнэн зөв байх, тохиолдсон байх Хэмжилт ба толилуулгын талаар батламж мэдэгдэлүүд зөрчигдөх эрсдэлтэй байна.

**Зөвлөмж**

Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын төсвийн багцын түвшин тус бүрийг шат шатанд нь нэгтгэх замаар салбарын хэмжээний худалдан авах ажиллагааг санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр нь нэгтгэж, удирдах тогтолцоо бий болгох удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

Энэ зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 онд багтаан шийдвэрлэх;

**Үйлчлүүлэгчийн хариу**

Холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ.

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31

/төгрөгөөр/

| БАЛАНСЫН ЗҮЙЛ                                | 12.12.31                     | 13.12.31                     |
|--|------------------------------|------------------------------|
| <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>                        | <b><u>55,586,300.04</u></b>  | <b><u>125,400,448.77</u></b> |
| Кассанд байгаа бэлэн мөнгө                   | 0.00                         | 81,884,191.01                |
| Төгрөг ЖМС                                   | 0.00                         | 81,884,191.01                |
| <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>            | <b>55,586,300.04</b>         | <b>43,516,257.76</b>         |
| <b>Төгрөг</b>                                | <b>55,586,300.04</b>         | <b>43,516,257.76</b>         |
| Улсын төсвийн харилцах                       | 51,802,000.04                | 0.00                         |
| Бусад төсөл, нөөцийн харилцах                | 3,784,300.00                 | 43,516,257.76                |
| <b>АВЛАГА</b>                                | <b><u>140,416,096.76</u></b> | <b><u>3,961,960.00</u></b>   |
| Ажиллагчидтай холбогдсон авлага              | 1,582,400.00                 | 0.00                         |
| <b>Бусад авлага</b>                          | <b>138,833,696.76</b>        | <b>3,961,960.00</b>          |
| <b>Байгууллагаас авах авлага</b>             | <b>138,833,696.76</b>        | <b>3,961,960.00</b>          |
| Бусад зардлын тооцооны авлага                | 138,833,696.76               | 3,961,960.00                 |
| <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                        | <b><u>628,678,826.87</u></b> | <b><u>678,829,336.39</u></b> |
| <b>Түүхий эд материал</b>                    | <b>283,447,754.59</b>        | <b>267,760,895.59</b>        |
| Тусгай зориулалттай материал                 | 275,883,824.59               | 267,760,895.59               |
| Бэлэн бүтээгдэхүүн                           | 7,563,930.00                 | 49,644,906.00                |
| <b>Хангамжийн материал</b>                   | <b>345,231,072.28</b>        | <b>361,423,534.80</b>        |
| Бичиг хэргийн материал                       | 1,105,100.00                 | 0.00                         |
| Бусад хангамжын материал                     | 344,125,972.28               | 361,423,534.80               |
| <b>НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>                | <b><u>824,681,223.67</u></b> | <b><u>808,191,745.16</u></b> |
| <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                        | <b><u>803,061,177.58</u></b> | <b><u>545,662,271.01</u></b> |
| <b>Биет хөрөнгө</b>                          | <b>793,458,677.63</b>        | <b>538,763,937.73</b>        |
| <b>Авто-тээврийн хэрэгсэл</b>                | <b>389,385,696.40</b>        | <b>57,637,250.00</b>         |
| Авто-тээврийн хэрэгсэл                       | 468,323,419.00               | 75,275,000.00                |
| Авто-тээврийн хэрэгсэл Хуримтлагдсан элэгдэл | 78,937,722.60                | 17,637,750.00                |
| <b>Машин тоног төхөөрөмж(компьютер)</b>      | <b>229,453,403.47</b>        | <b>324,281,168.24</b>        |
| Машин тоног төхөөрөмж(компьютер)             | 460,056,494.04               | 596,092,832.04               |

|   |                                |                                |
|---|--------------------------------|--------------------------------|
| Машин тоног төхөөрөмж(компьютер)<br>Хуримтлагдсан элэгдэл | 230,603,090.57                 | 271,811,663.80                 |
| <b>Тавилга, аж ахуйн эд хогшил</b>                        | <b>172,477,425.01</b>          | <b>151,106,307.74</b>          |
| Тавилга, аж ахуйн эд хогшил                               | 268,611,972.64                 | 272,423,871.64                 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил Хуримтлагдсан<br>элэгдэл      | 96,134,547.63                  | 121,317,563.90                 |
| <b>Бусад үндсэн хөрөнгө</b>                               | <b>2,142,152.75</b>            | <b>5,739,211.75</b>            |
| Бусад үндсэн хөрөнгө                                      | 21,775,987.86                  | 21,775,987.86                  |
| Хуримтлагдсан элэгдэл                                     | 19,822,835.11                  | 20,538,083.11                  |
| Номын фонд  | 189,000.00                     | 4,501,307.00                   |
| Хуримтлагдсан элэгдэл                                     | 0.00                           | 0.00                           |
| Дуусаагүй барилга, байгууламж                             | 0.00                           | 0.00                           |
| <b>Биет бус хөрөнгө</b>                                   | <b>9,602,499.95</b>            | <b>6,898,333.28</b>            |
| <b>Програм хангамж</b>                                    | <b>9,602,499.95</b>            | <b>6,898,333.28</b>            |
| Програм хангамж   | 13,605,913.00                  | 13,605,913.00                  |
| Программ-Хасалдуулга                                      | 4,003,413.05                   | 6,707,579.72                   |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>                              | <b><u>80,035,392.09</u></b>    | <b><u>545,662,271.01</u></b>   |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                 | <b><u>1,627,742,401.25</u></b> | <b><u>1,353,854,016.17</u></b> |
| <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                          | <b>0.00</b>                    | <b>18,703,753.87</b>           |
| <b>Өглөг</b>  | <b>0.00</b>                    | <b>18,703,753.87</b>           |
| <b>Бараа үйлчилгээний зардлын тооцоо</b>                  | <b>0.00</b>                    | <b>811,007.87</b>              |
| Бусад зардлын тооцоо                                      | 0.00                           | 811,007.87                     |
| <b>Бусад өглөг</b>  | <b>0.00</b>                    | <b>17,892,746.00</b>           |
| Байгууллагад төлөх өглөг                                  | 0.00                           | 17,892,746.00                  |
| <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                     | <b><u>0.00</u></b>             | <b><u>18,703,753.87</u></b>    |
| <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                        | <b>1,627,742,401.25</b>        | <b>1,335,150,262.30</b>        |
| Засгийн газрын оруулсан капитал                           | 361,931,001.51                 | 361,931,001.51                 |
| <b>Хуримтлагдсан үр дүн</b>                               | <b>1,237,160,306.30</b>        | <b>944,568,167.35</b>          |
| Өмнөх үеийн үр дүн  | 1,237,160,306.30               | 903,471,131.20                 |
| Тайлант үеийн үр дүн                                      | 0.00                           | 41,097,036.15                  |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                          | 28,651,093.44                  | 28,651,093.44                  |
| <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                           | <b><u>1,627,742,401.25</u></b> | <b><u>1,335,150,262.30</u></b> |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                | <b><u>1,627,742,401.25</u></b> | <b><u>1,353,854,016.17</u></b> |



## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант үе: 2013/01/01 - 2013/12/31

/төгрөгөөр/

| <b>БАЛАНСЫН ЗҮЙЛ</b>  | <b>12.12.31</b>         | <b>13.12.31</b>         |
|---|-------------------------|-------------------------|
| <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                            | <b>5,092,131,174.04</b> | <b>8,607,898,400.00</b> |
| <b>Гадаад орнуудаас үзүүлсэн</b>                                | <b>190,927,374.04</b>   | <b>157,689,800.00</b>   |
| Хөрөнгийн   | 190,927,374.04          | 157,689,800.00          |
| <b>Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт</b>    | <b>5,092,131,174.04</b> | <b>8,450,208,600.00</b> |
| <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                  | <b>5,092,131,174.04</b> | <b>8,450,208,600.00</b> |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                               | 4,901,203,800.00        | 7,675,259,700.00        |
| Хөрөнгийн   | 0.00                    | 774,948,900.00          |
| <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>                                      | <b>814,101,806.34</b>   | <b>623,951,849.00</b>   |
| <b>Бараа, үйлчилгээний борлуулалт</b>                           | <b>814,101,806.34</b>   | <b>623,951,849.00</b>   |
| <b>Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого</b>         | <b>814,101,806.34</b>   | <b>623,951,849.00</b>   |
| Үндсэн үйл ажиллагааны орлого                                   | 17,607,356.00           | 11,633,800.00           |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого                               | 432,826,502.34          | 111,667,496.00          |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого                               | 363,667,948.00          | 500,650,553.00          |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                          | <b>5,906,232,980.38</b> | <b>9,231,850,249.00</b> |
| <b>АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ</b>                                       | <b>1,085,823,396.00</b> | <b>1,296,865,232.13</b> |
| <b>Үндсэн болон нэмэгдэл цалин</b>                              | <b>983,935,296.00</b>   | <b>1,159,340,481.01</b> |
| Үндсэн цалин  | 924,373,596.00          | 1,076,147,581.01        |
| Унаа хоолны хөнгөлөлт   | 49,005,000.00           | 61,533,000.00           |
| <b>Бусад нэмэгдлүүд</b>   | <b>10,556,700.00</b>    | <b>21,654,900.00</b>    |
| Унаа, болон бусад нөхөн олговор                                 | 10,556,700.00           | 21,654,900.00           |
| <b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>                              | <b>101,888,100.00</b>   | <b>137,529,751.12</b>   |
| <b>Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл</b>                        | <b>101,888,100.00</b>   | <b>137,529,751.12</b>   |
| Тэтгэврийн даатгалын шимтгэл                                    | 101,888,100.00          | 137,529,751.12          |
